

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2023 ОНЫ 4-Р УЛИРЛЫН МЭДЭЭ

2023.12.26

2023 оны 4-р улирлын байдлаар Засаг даргад 50, Засаг даргын Тамгын газарт 11, нийт 61 өргөдөл хүлээн авч тус өргөдлүүдийг бүрэн шийдвэрлэсэн.

Засаг даргын Тамгын газарт иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, санал шийдвэрлэлтийн талаар авсан арга хэмжээ:

Өмчлөлийн газрын талбайн хэмжээний зөрүүг арилгаж өгөх тухай 3 өргөдлийг Засаг даргын 2023 оны A/18, A/30, A/40 дугаар захирамжаар тус бүр шийдвэрлэсэн.

Харгалзан дэмжигчээр тогтоох тухай 2 өргөдөл, асран хамгаалагчаар тогтоох тухай 2 өргөдөлд сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн A/39 дугаар захирамжаар, 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн A/108 дугаар захирамжаар, сумын Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн A/152 дугаар захирамжаар тус тус тогтоосон. Асран хамгаалагчаар тогтоох 1 өргөдөлд тус иргэн нь асаргаанд байдгийг нотолсон эмнэлгийн бичиг байхгүй тул асран хамгаалагчаар тогтоох боломжгүй тухай хариуг өгсөн. Хүүхдийн овог нэр өөрчлөх тухай хүсэлт ирснийг Говьсүмбэр аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүх болон Улсын бүртгэлийн хэлтэст өргөдөл гаргаж шийдвэрлүүлэх тухай хариуг өгсөн.

Гэр хүссэн 4 өргөдөлд гэр олгох боломжгүй тухай мэдэгдэж, өргөдлийг хяналтанд авсан.

Тэмцээн зохион байгуулахад дэмжлэг хүссэн 1 өргөдөлд Засаг даргын 2023 оны A/32 дугаар захирамжаар 331,500 (гурван зуун гучин нэгэн мянга таван зуу) төгрөгийн дэмжлэг, Хүүхдийн хагалгааны зардалд хандив тусlamж хүссэн өргөдөлд сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн A/50 дугаар захирамжаар 300,000 (гурван зуун мянга) төгрөг, эмчилгээний зардалд тусlamж хүссэн өргөдөлд сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн A/49 дүгээр захирамжаар 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөгийн тусlamжийг тус тус үзүүлж, Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан. Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Өөдрөг зөвлөл холбоо”-ноос дэмжлэг хүссэн өргөдөлд сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн A/83 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,949,000 (нэг сая есөн зуун дөчин есөн мянга) төгрөгийг зарцуулж, телевизор, дуу өсгөгч худалдан авч өгсөн. Сумын Хүүхдийн зөвлөлөөс арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг хүссэн өргөдлийн дагуу Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн зардлаас 200,200 (хоёр зуун мянга хоёр зуу) төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Нэлөөллийн бүсэд байгаа малчин өрхүүдэд дэмжлэг үзүүлэх тухай хүсэлт ирснийг Страто ХХК-д уламжилж өгсөн. Дэлгүүрийн ажиллах цагийн хуваарыт өөрчлөлт оруулж өгөхийг хүссэн 1 өргөдөлд Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 1/99 тоот албан бичгээр хариуг өгсөн.

Газар эзэмших хугацааг сунгах тухай 1 өргөдөл, Газар эзэмшихийг хүсэх тухай 3 өргөдөл, мөн өвөлжөө, хаваржааны газар хүссэн 10 өргөдлийг газрын координатын цэгийг тогтоож, сумын 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхэд тус газартай холбоотой хүсэлтүүдийг багийн Иргэдийн Нийтийн хурлын тогтоол гараагүй, тогтоолоор батлаагүй гэсэн үндэслэлээр газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд батлагдаагүй болно. Дахин багийн Иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлж, тогтоол гарган сумын Газар зохион байгуулалтын 2024 оны төлөвлөгөөнд нэмэлтээр санал тусган сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд уламжлахаар шийдвэрлэв. Газар эзэмшүүлэх захирамж шүүж өгөх тухай өргөдлийн дагуу сумын архиваас Засаг даргын захирамж шүүж үзэхэд газар эзэмшүүлэх тухай захирамж гараагүй болохыг мэдэгдсэн. Газар өмчлөх тухай 1 хүсэлтэд сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 1/198 тоот албан бичгээр хариуг өгсөн. Газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай 1 өргөдөлд сумын Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 1/176 тоот албан бичгээр хариуг өгсөн. Хүнсний ногоо тариалах талбайн зөвшөөрөл хүссэн өргөдөлд сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 1/217 тоот албан бичгээр хариуг өгсөн. Өмчлөлийн газар дээр өрөмдлөг хийлгэх тухай өргөдөлд сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 1/193 тоот албан бичгээр хариуг өгсөн. Өвөлжөөний газар хүссэн 1 иргэний өргөдөлд 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 1/280 тоот албан бичгээр хариуг өгсөн. Эзэмшлийн газрын газар эзэмших хугацааг сунгах тухай 1 өргөдөлд сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/131 дугаар захирамжаар сунгасан. Газар эзэмших зориулалтыг өөрчилж өгөх тухай өргөдлийн дагуу саналыг сумын 2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган батлуулсан.

Сумын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооноос “Бид хамтдаа” спортын арга хэмжээнд оролцоход дэмжлэг хүссэн өргөдөлд замын зардлын 60,000 (жаран мянга) төгрөгийг шийдвэрлэж өгсөн. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг шилжүүлж өгөх тухай өргөдөлд сумын Хамтарсан багийн Нарийн бичгийн дарга, багийн Засаг дарга гэрт нь очиж нөхцөл байдлын үнэлгээ хийсэн. Оршин суугчдаас Нийтийн эзэмшлийн орон сууцны байранд засвар хийж өгөхийг хүссэн 1 өргөдөл ирсний дагуу тус өргөдлийг сумын Улаан загалмайн анхан шатны хороонд 2023 оны 05 дугаар сарын

22-ны өдрийн 2/229 тоот албан бичгээр хүсэлтийг уламжилсан. Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөл хүссэн 1 өргөдлийг сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/67 дугаар захирамжаар тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаатай олгосон. Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай 1 өргөдлийг сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/146 дугаар захирамжаар 2 жилийн хугацаатайгаар сунгасан.

Хүүхэд харах үйлчилгээ ажиллуулах байр түрээсэлж байсан иргэн түрээсийн гэрзэгээ цуцлуулах тухай өргөдөл өгсний дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 3/424 тоот албан бичгээр хүсэлтийг уламжилсан. Тодорхойлолт хүссэн 3 иргэний өргөдөлд Хаан банкны Шивээ Овоо тооцооны төвд 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 1/393 тоот албан бичгээр, Сүмбэр сумын ЗДТГ-т 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 1/426 тоот албан бичгээр, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 1/501 тоот албан бичгийг уламжилсан. Max сүү худалдан борлуулах түр цэг ажиллуулахыг хүссэн иргэний өргөдлийн дагуу тус иргэнтэй 6 сарын хугацаатай гэрээ байгуулж, Төв талбайд худалдаа явуулах зөвшөөрлийг олгосон.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг авдаг асран хамгаалагчийг цуцлуулж, тухайн хүүхдийн өөрийнх нь данс руу шилжүүлж өгөхийг хүссэн өргөдлийг аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт шилжүүлсэн.

Малжуулах төсөлд хамрагдах хүсэлтэй 5 иргэний өргөдлийн дагуу төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэрээр тус 5 иргэнд нийт 106 ямаа, 168 хонь, 8 ишиг, 8 хургыг хүлээлгэн өгсөн.

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛӨГЧ

Б.УУГАНБАЯР



ЗАСАГ ДАРГА

Х.СУГАРМАА

2023 оны жилийн эцсийн байдлаар

Байгууллагын нэр	Өргөдөл голмортын төрөл				Хүлээн авсан хэлбэр				Албан бичгээр
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биөэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөс шилжүүлсэн	
Тайлбар:	1	2	3	4					5
Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтын шийдвэр, уйл ажиллагаагаар иргэдийн хулиар хамгаалаадсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гарласан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтын уйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гарасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, Үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, сошиал платформ, мэйл г.м		11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн
Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар	0	0	0	0	61	0	0	0	0

2022 оны жилийн эцэстэй харьцуулсан ДУН

Байгууллагын нэр	Өргөдөл голмортын төрөл				Хүлээн авсан хэлбэр				Албан бичгээр
	Мэдэгдэл	Гомдол	Санал	Хүсэлт	Биөэр	Утсаар	Цахимаар	11-11 төвөс шилжүүлсэн	
Тайлбар:	1	2	3	4					5
Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргээс гарсан хүсэлт	Төрийн байгууллага албан тушаалтын шийдвэр, уйл ажиллагаагаар иргэдийн хулиар хамгаалаадсан эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гарласан хүсэлт	Төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтын уйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гарасан иргэний хүсэлтийг	Байгууллагын дотоод асуудал, Үйлчилгээ авах хүсэлтээс бусад	Иргэн өөрийн биеэр ирж, өргөдөл өгсөн	Байгууллагын тусгай дугаараар	Вэб сайт, сошиал платформ, мэйл г.м		11-11 төвд бүртгэгдэн, цахимаар шилжүүлэн	ААНБ, хуулийн этгээдээс албан бичгээр ирүүлсэн
Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар	0	0	0	55	0	0	0	0	0

Гомдлын агуулга	Тоо	Хувь	Өргөдөл гомдлыг бууруулахад цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал
Газар эзэмших, өмчлөх, газрын зориулалтыг өөрчлөх	28	46.00	
Санхүүгийн дэмжлэг, тусlamж хүссэн	7	11,5	
Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох	5	8,2	
Гэр хүссэн	4	6,5	
Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөл хүссэн	2	3,3	
Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой	2	3,3	
Хүүхэд үрчлэлтэй холбоотой	1	1,6	
Тодорхойлолт хүссэн	3	4,9	
Худалдаа явуулах түц байршуулан ажиллуулах зөвшөөрөл хүссэн	1	1,6	
Дэлгүүрийн ажиллах цагийн хуваарыт өөрчлөлт оруулах тухай	1	1,6	
Хүүхдийн овог нэр өөрчлөх тухай	1	1,6	
Түрээсийн гэрээ цуцлуулах тухай	1	1,6	
Малжуулах төсөлд хамрагдах тухай	5	8,3	
	61	100.00	